

Хөдөлмөр цалин хөлсний товчоо

1964-12-16-нд Сайд нарын Зөвлөлийн 650-р тогтоолоор Улаанбаатар хотын **тоо бүртгэлийн товчооны** орон тоог 5 нэгч, сарын цалингын фондыг 3150 төгрөгөөр баталжээ.

1962-5-11-нд Сайд нарын Зөвлөлийн 233-р тогтоолоор Налайхыг хот болгосонтой холбогдуулж уг хотын захиргааны орон тоог 19 нэгчээр, **сарын цалингийн фондыг 9470** төгрөгөөр баталжээ.

Зохион байгуулалт нь:

- -Удирдах хэсэг
- -Нийгэм соёлын хэлтэс
- -Санхүүгийн аж ахуйн хэлтэс гэж байжээ.
- 1962-6-21-нд Сайд нарын Зөвлөлийн 329-р тогтоолоор аймаг, **хотын аж ахуй соёлын зарим асуудал**, хөдөлмөрчдийн эрэлт хүсэлтийг хөнгөн шуурхай шийдвэрлэж байх зорилгоор: Аймаг, хотын АДХ-ы гүйцэтгэх захиргаадад захиргааны дарга орлогчид, хариуцлагатай нарийн бичгийн дарга, **санхүүгийн хэлтсийн дарга** нарын бүрэлдэхүүнтэй товчоо байгуулахаар тогтоожээ.

1962-11-30-нд Намын Төв хорооны улс төрийн Товчооны 377 дугаар тогтоол, 1962-12-6-нд Улсын их хурлын тэргүүлэгчдийн зарлиг, 1962-12-6-нд Сайд нарын Зөвлөлийн 603-р тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын **Хөдөлмөр цалин хөлсний товчоог** 6 нэгчээр байгуулжээ.

1965-3-9-нд Сайд нарын Зөвлөлийн 61-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны дэргэд Батлан хамгаалах хөдөлмөр, нийгэмлэгийн штабыг 1965-3-1-нээс 3 хүний орон тоотой байгуулахаар тогтоожээ.

- 1968-6-7-нд Сайд нарын Зөвлөлийн 185 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалтыг
- -Зохион зааварлах хэлтэс
- -Төлөвлөгөөний комисс

- -Санхүүгийн хэлтэс
- -Ардын боловсролын хэлтэс
- -Соёлын хэлтэс
- -Их барилгын хэлтэс
- -Аж ахуйнхэлтэс
- -Хөдөлмөр цалин хөлсний товчоо
- -Иргэний хамгаалаты нштаб

Эрүүлийг хамгаалах газар гэж батлаад орон тоог 88 нэгчээр тогтоожээ